

**ШҮҮГЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРААТ
БУС БАЙДАЛ БА ШҮҮХИЙН ТӨСӨВ**



ЛАВЛАГАА

**Шүүхийн ерөнхий
зөвлөлийн дарга,
гишүүнд танилцуулах
нь**



ШҮҮГЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ БА ШҮҮХИЙН ТӨСӨВ /ЛАВЛАГАА/¹

ГАРЧИГ

Удиртгал	3
Нэг. Олон улсын эрх зүй дэх шүүхийн төсөв болон шүүгчийн цалинтай холбоотой зөвлөмж, уриалга	4
1.1. НҮБ-ын Шүүхийн бие даасан байдлын суурь зарчмууд	4
1.2. Олон улсын шүүгчдийн дүрэм	4
1.3. Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софигийн тунхаглал	5
Хоёр. Шүүхийн төсвийг боловсруулж, батлуулж байгаа гадаад орны туршлага	5
- Оросын Холбооны Улс	
- Канад Улс	
- Бүгд Найрамдах Итали Улс:	
- ХБНГУ	
- Болгар Улс	
- Унгар улсын шүүхийн захиргаа	
- Швед Улс	
- АНУ	
Дүгнэлт	16
Хавсралт	17
- Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софигийн тунхаглал	17
- Европ дахь шударга ёсны ирээдүйн асуудлаарх Варшавын тунхаг	18

¹ Нэгтгэн боловсруулсан Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын судлаач Л.Галбаатар. Лавлагааны хоёр дахь хэсгийг боловсруулсан тус хүрээлэнгийн захирал Ц.Мандах, Шүүхийн судалгаа хариуцсан ахлах референт Э.Өлзийлхам.



Удиртгал

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд “23.5. Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй” гэж заасан байсан хэдий ч Улсын Их Хурал тус заалтыг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосон.

Үүнийг Олон улсын шүүгчдийн холбоо (International Association of Judges)–ноос шүүхийн хараат бус байдлыг хангахад сөргөөр нөлөөлж болохыг тайлбарлан шүүмжилсэн байдаг. Тодруулбал, “шүүгчийн ажил, амьдрал баталгаатай байх нь бие даасан шүүхтэй, хуулийн засаглалтай улс оронд хамгийн тулгуур хүчин зүйл байдаг. Шүүгчийн цалин хөлсийг бууруулах нь шүүхийн бие даасан байдал болон эрх зүйт төрийн суурь зарчмыг хөндөхөд хүргэдэг. Улс орны эдийн засгийн нөхцөл байдал Засгийн газрыг зарим тохиолдолд төсвийн асуудлаар амаргүй шийдвэр гаргахад хүргэж болох хэдий ч энэхүү шийдвэр нь ямагт Үндсэн хуулийн суурь зарчмуудыг хамгаалсан, тэдгээрт нийцсэн байх учиртай. Хууль ёсыг сахиулах үүргийг тухайлан хүлээсэн шүүхийн байгууллага нь улс орны хувьд онцлог үүрэг бүхий төрийн эрх мэдлийн бие даасан салбар юм. Шүүхийн бие даасан байдал нь төрийн өөрийнх нь хэвийн, зохистой ажиллагааг хангахад болон өдөр тутмын ахуй, амьдрал нь хуулийн дагуу зохицуулагддаг бүх хүний хувьд онцгой ач холбогдолтой асуудал билээ. Шүүх нь иргэдийн дунд төдийгүй, иргэд - төр, засгийн байгууллагуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд чухал үүрэгтэй. Хуулийн дагуу маргааныг шийдвэрлэх үүрэгтэй этгээд нь ямар нэгэн айдас, нөлөөгүйгээр тэрхүү үүргээ хэрэгжүүлнэ гэсэн итгэл, үнэмшил тухайн эрх зүйт төрт улсад амьдарч буй ард иргэдэд тогтсон байх нь нэн чухал. Харин шүүгчийн ажиллах баталгааг хасч, бууруулах нь маргааны нэг тал болж оролцдог гүйцэтгэх эрх мэдлийн нөлөөнд шүүхийг автагдах магадлалтай болгож, улмаар хууль ёсонд итгэх иргэдийн итгэл үнэмшлийг үгүй хийх аюултай” тул Олон улсын шүүгчдийн холбооноос Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлын энэхүү сөрөг үр дагавартай алхамаа яаралтай эргэн харж, залруулахыг уриалсан байдаг.²

Гэвч энэ байдлыг хууль тогтоох байгууллага анхаарч, залруулга хийгээгүй өдийг хүрсэн. Үүнээс гадна Засгийн газраас 2016.08.23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шүүхийн урсгал төсвийн зардлыг батлагдсан хэмжээнээс 3.9 тэрбум төгрөгөөр, шүүгчийн цалингийн санг 3.2 тэрбум төгрөгөөр бууруулахаар тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн шинжтэй үйлдэл болж байна.³

Иймд энэхүү лавлагаагаар шүүгчийн эдийн засгийн хараат бус байдал ба шүүхийн төсөвтэй холбоотой олон улсын хэмжээ, бусад улсын сайн туршлагыг танилцуулж байна.

² Олон улсын шүүгчдийн холбоо (International Association of Judges) -ны Ази, Номхон далай, Хойд Америкийн Бүсийг Ерөнхийлөгчөөс хандаж Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдад хандаж илгээсэн захидал. 2015.10.21 <http://judge.mn/home/view/?id=223>

³ Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 2016.08.23 <http://www.parliament.mn/laws/projects/913>



НЭГ. ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ ДЭХ ШҮҮХИЙН ТӨСӨВ БОЛОН ШҮҮГЧИЙН ЦАЛИНТАЙ ХОЛБООТОЙ ЗӨВЛӨМЖ, УРИАЛГА

Шүүгчдийг нэгтгэсэн олон улсын байгууллагууд шүүхийн төсөв болон шүүгчийн цалинтай холбоотой асуудлаар албан ёсны байр сууриа холбогдох баримт бичгээр илэрхийлсэн байдаг. Үүнд:

- НҮБ-ын Шүүхийн бие даасан байдлын суурь зарчмууд, 1985 он
- Олон улсын шүүгчдийн дүрэм (Олон улсын шүүгчдийн холбоо-1999 он)
- Европын холбооны Сайд нарын зөвлөлийн CM/REC/(2010)12 дугаар Зөвлөмж
- Шүүгчийн эрх зүйн байдлын талаарх Европын шүүгчдийн дүрэм, 1998 он
- Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софигийн тунхаглал, 2010 он

зэрэг баримт бичгийг нэрлэж болно.

Тухайлбал, Монголын шүүгчдийн холбооноос гишүүнээр элссэн “Олон улсын шүүгчийн холбоо”-ны зүгээс 2012.11.15-ны өдөр баталсан тогтоолдоо дараах зүйлийг тэмдэглэсэн байна. Үүнд:

- Эдийн засгийн гүн хямралтай үед ч шүүгчдийн цалинг зайлшгүй тохиолдолд гагцхүү хүлээн зөвшөөрөгдөж болохуйц хамгийн бага, зохистой хэмжээнд бууруулан тогтоох нь зүйтэй,
- шүүгчдийн цалинг бууруулах нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хөндөж байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй,
- Нэлээд хэдэн улсад шүүгчийн цалинг бууруулан тогтоосон асуудал нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр Үндсэн хуульд нийцээгүй хэмээн тогтоогдсон гэжээ.⁴

1.1. НҮБ-ын Шүүхийн бие даасан байдлын суурь зарчмууд⁵

11-р зарчим: “Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, хараат бус, аюулгүй байдал, зохистой цалин хөлс, ажлын нөхцөл, тэтгэвэрт гарах, тэтгэвэр авах хангалттай баталгааг хуулиар тогтооно”.⁶

1.2. Олон улсын шүүгчдийн дүрэм

⁴ The Central Council of the International Association of Judges, convened in Washington D.C. on November 15th, 2012 adopts the following Resolution

http://www.uhs.hr/data_sve/docs/CC_risoluzione_salari_EN.pdf

Тус тогтоолыг Монголын Шүүгчдийн холбооны гишүүн, шүүгч Ц.Цогт англи хэлнээс монгол хэл дээр орчуулсныг тус холбооны цахим хуудаснаас харж болно. <http://judge.mn/home/view/?id=179>

⁵ Тус баримт бичгийг 1985.08.26-1985.09.06-нд Милан хотноо болсон НҮБ-ын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ялтанг хүмүүжүүлэх 7 дугаар чуулганаас баталсан бөгөөд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985.11.29-ний өдрийн 40/32 тоот тогтоол болон 1985.12.13-ны өдрийн 40/146 тоот тогтоолоор дэмжиж зөвшөөрсөн.

Basic Principles on the Independence of the Judiciary

<http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/IndependenceJudiciary.aspx>

⁶ Conditions of service and tenure

11. The term of office of judges, their independence, security, adequate remuneration, conditions of service, pensions and the age of retirement shall be adequately secured by law.



13-р зүйл: *“Шүүгч нь эдийн засгийн хувьд бие даасан байх нөхцөлийг бодитоор, бүрэн хангахуйц цалингаар хангагдах ёстой. Цалин нь шүүгчийн ажлын үр дүнгээс хамаарах учиргүй бөгөөд шүүгчээр ажиллах бүхий л хугацаанд буурахгүй байх”*⁷

1.3. Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай Софигийн тунхаглал

Европын холбоо 2010 оноос шүүхийн шинэтгэл хийж эхэлсэн. Энэхүү шинэтгэлийн зорилтын нэг нь “шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэхийн хамт хариуцлагатай байдлыг хангах” арга хэмжээг авч хэрэгжүүлэх юм. Улмаар 2013 онд “Шүүхийн бие даасан байдал болон хариуцлагын тухай” Софигийн тунхаглалыг баталсан. Тус тунхаглалаар шүүх эрх мэдлийг баталгаажуулж, шүүхийн төсвийг засгийн газрын зардлын хэмнэлт хийх зорилгоор танахгүй байхыг уриалсан байна.⁸

2013 оны 6 дугаар сарын 5-7-ны хооронд Болгар улсын нийслэл Софи хотод ЕШЗХ-ны Ерөнхий ассамблей хуралдаж, “Шүүхийн бие даасан байдал болон хариуцлага” гэсэн асуудлаар зөвлөлджээ. Хуралдаанаас гарсан тунхаглалыг Софигийн тунхаглал гэж албан ёсоор нэрлэсэн. Софигийн тунхаглал нь хараат бус шүүхийн үр нөлөө, мөн энэхүү хараат бус байдлыг бэхжүүлэх шүүхийн зөвлөлийн гол үүргийг тунхаглажээ. Тус тунхаглалын 3 дугаар зүйлд “Засгийн газрын зардал хэмнэлт нь шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг сулруулж болохгүй” гэсэн бол мөн тунхаглалын 4 дүгээр зүйлд “Санхүүгийн тогтвортой байдал, ажлын байрны баталгаа, захиргааны бие даасан байдал нь бие даасан, хараат бус шүүхийн зайлшгүй хамгаалалт болно” гэж шүүхийн бие даасан, хараат бус байдлыг баталгаажуулж, шүүхийн төсвийг засгийн газраас зардлын хэмнэлт хийх зорилгоор бууруулж болохгүй гэдгийг Европын Холбооны бүхий л улс орнуудад уриалсан байна. / Софигийн тунхаглалыг хавсралтаас үзнэ үү/

ХОЁР. ШҮҮХИЙН ТӨСВИЙГ БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛЖ БАЙГАА ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА⁹

Шүүгчийн эдийн засгийн баталгаа нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах гол нөхцөл болдог. Шүүх бие даасан, шүүгч хараат бусаар ажиллах нөхцөл, боломжоор хангагдсан байх нь шударга ёс, хуулийн засаглалыг бэхжүүлэх төдийгүй хүний эрх, эрх чөлөөний тулгуур зарчмуудыг хэрэгжүүлэх үндэс суурь юм. Шүүхийн эдийн засгийн бие даасан байдлыг хангахын тулд зарим улсад шүүхийн төсвийг улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг болгож, түүний хэмжээг тодорхойлох хандлага байдаг. Энэ нь нэг талаар шүүхийг бусад эрх мэдлээс хараат бус байлгах, шүүх чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөрөнгийг

⁷ The Universal Charter of The Judge, International Association of Judges

Art. 13. Remuneration and retirement

The judge must receive sufficient remuneration to secure true economic independence. The remuneration must not depend on the results of the judges work and must not be reduced during his or her judicial service. The judge has a right to retirement with an annuity or pension in accordance with his or her professional category. After retirement a judge must not be prevented from exercising another legal profession solely because he or she has been a judge.

<http://www.iaj-uim.org/universal-charter-of-the-judges/>

⁸ Шүүгчийн бие даасан байдал ба хариуцлагын тухай Софигийн тунхаглал. Европын Шүүгчдийн зөвлөлийн зөвлөл. 2013. (The General Assembly of ENCJ Meeting Sofia 5th – 7th June, 2013 Sofia Declaration “On judicial independence and accountability”)

⁹ Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн. Судалгааны тайлангийн эмхэтгэл (2014 он).

“Шүүхийн төсөв: Шүүхийн төсвийг боловсруулж, батлуулж байгаа гадаад орны туршлага”.

Улаанбаатар. 2015. 189-195 дахь тал.



бэхжүүлэх зорилготой юм. Шүүхийн төсвийг боловсруулах, батлах талаар гадаад улс орны туршлагыг судалж, Монгол Улсын хууль тогтоомжид нарийвчлан зохицуулж оруулах шаардлага байгаа тул энэ удаа шүүхийн төсвийг хэрхэн боловсруулж, аль субъект өргөн барьж батлуулж байгаа талаар гадаадын зарим улсын туршлагаас судалсныг тоймлон хүргүүлж байна.


Шүүхийн төсвийг батлах тусгай процесс байдаг ба төсвийн төслийг төлөвлөх, санал болгох эрхийг Ерөнхий шүүгчийн ажлын алба, шүүхийн зөвлөл, засгийн газрын мэргэшсэн агентлаг, гүйцэтгэх засаглалын сайд нь бие даан боловсруулдаг загвар байдаг бол шүүх нь өөрөө парламентад шууд өргөн мэдүүлдэг процесс ч бас байдаг байна.¹⁰ Түүнчлэн өргөн барьсан шүүхийн төсвийн төслийг гүйцэтгэх эрх мэдлээр дамжуулж өргөн барихдаа гүйцэтгэх эрх мэдлээс шүүхийн төсвийг бууруулахгүй байх зарчмыг зарим орон баримталдаг байна. Шүүхийн төсвийг хэрхэн боловсруулж, батлуулж байгаа гадаадын зарим орны туршлагаас судалсныг танилцуулж байна.



¹⁰ A.Seibert (ed), Judicial Independence in Transition, Springer press, 2012. p.57.



График 1. Шүүхийн төсөв тухайн улсын нийт төсөвт эзэлж буй хувь хэмжээ



Оросын Холбооны Улс:

ОХУ-ын Үндсэн хуулийн 124 дүгээр зүйлд шүүхийн төсвийг зөвхөн холбооны улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж заасан байдаг. Түүнчлэн шүүхийн төсвийн асуудлыг ОХУ-ын Холбооны төсвийн тухай хууль, Шүүхийг санхүүжүүлэх тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулдаг. ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Арбитрын дээд шүүхийн үйл ажиллагааг хангахын тулд Холбооны төсвийн тухай хуульд төсвийн бие даасан байдлыг хангах тухай эрх зүйн зохицуулалтыг оруулсан. Тухайлбал, шүүхүүдийн тухайн жилийн санхүүгийн, эсхүл дараагийн жилийн баталсан төсвийг танах бол зөвхөн ОХУ-ын Шүүхийн зөвлөлийн зөвшөөрөлтэйгөөр 5-аас илүүгүй хувийг хасах, мөн дээрх байгууллагууд нь төсвөө бие даан зарцуулах зэрэг зохицуулалтыг тусгасан байдаг. Түүнчлэн ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх, Дээд шүүх, Арбитрын дээд шүүх зохион байгуулалт, санхүү, материаллаг болон техник хангамжийн хувьд бусад байгууллагаас хараат бус байх, энэ төсвийг бие даан зарцуулах зохицуулалтыг ОХУ-ын Үндсэн хууль, Холбооны улсын төсвийн тухай хуульд тусгасан бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн



төсвийн дүнг өмнөх жилийн дүнгээс хасаж, бууруулж болохгүй талаар мөн тусгажээ.

ОХУ-ын Засгийн газар, Шүүхийн дээд зөвлөлийн даргатай хамтран тухайн жилдээ дараагийн жилийн шүүхийн санхүүжилтийн төсвийн төслийг боловсруулдаг. Улмаар ОХУ-ын Төрийн дум шүүхийн төсвийг баталдаг. Хэрэв төслийг боловсруулахад саналын зөрүү гарах тохиолдолд Засгийн газар төсөлдөө шүүхийн төсөвтэй холбогдох төслийн саналыг хавсаргаж өгөх ёстой байдаг.¹¹ ОХУ-ын 1998 оноос 2004 оны хооронд шүүхийн төсвийн зарцуулалтыг нийт улсын төсөвт үзүүлж байгаа хувиар харуулбал:¹² 1998 онд 0,9%, 2000 онд 1,0%, 2002 онд 1,0%, 2003 онд 1.1%, 2004 онд 1,2% тус тус эзэлсэн бөгөөд 2012 онд 2.1% болж өсчээ.

Канад Улс:

Үндсэн хуулийн акт */The Constitution Act, 1867/* болон Дээд шүүхийн акт */Supreme court act/*-аар Канад улсын шүүхийн бие даасан байдал, төсвийн харилцааг зохицуулсан.¹³ Канад улсын Холбооны шүүхийн комиссарын газар */Office of the Commissioner for Federal Judicial Affairs Canada/* нь Хууль зүйн яаманд ажлаа тайлагнадаг ба шүүхийн бие даасан байдлыг хангах баталгааг хэрэгжүүлдэг ба шүүгчид албан үүргээ Хууль зүйн яамнаас хамааралгүйгээр хэрэгжүүлдэг. Энэ газар нь Канадын Шүүхийн зөвлөлийн */Judicial Council/* төсвийн төслийг боловсруулдаг.¹⁴ Шүүхийн төсвийг батлахад Засгийн газар нөлөө үзүүлэх хэмжээнд оролцдоггүй. Шүүх нь төсвөө боловсруулж Холбооны Улсын Засгийн газрын Сангийн хороо */Treasury Board/*-нд өргөн мэдүүлдэг. Шүүх нь өөрөө бус харин Засгийн газар нь улсын төсвийн зарцуулалтыг татвар төлөгчид тайлагнадаг. Засгийн газар нь санхүүгийн эрх мэдлээ ашиглан шүүхийн шүүн таслах ажиллагаанд нөлөөлөх гэж оролддоггүй байна.¹⁵ Шүүхийн төсвийг Парламент нь баталдаг.¹⁶

Бүгд Найрамдах Итали Улс:

Итали Улсад шүүхийн үйл ажиллагааны зардал улсын төсвөөс гардаг ба Шүүхийн дээд зөвлөлийн эрх хэмжээнээс бусад зохион байгуулалт болон захиргаатай холбоотой бүхий л үйл ажиллагааны төсвийн асуудлыг Хууль зүйн сайд хариуцдаг. Хууль зүйн яам болон Сангийн яам шүүхийн төсвийг боловсруулж, Парламентад өргөн барьдаг. Яамд нь шүүх тус бүрээр нь төсвийг хуваарилж, зохицуулдаг. Үндсэн хуулийн шүүх нь өөрөө бие дааж төсвөө боловсруулж, Парламентаар батлуулахаар өргөн барьдаг.¹⁷ Шүүхийн төсвийн тухай хуулийг батлах процесс нь хууль батлах процесстой адил ба тус хуулийн төслийг Засгийн газар өргөн мэдүүлж Итали Улсын Парламент баталдаг.¹⁸ Итали Улс 2010 онд бүх

¹¹ http://uristprosto.ru/?page_id=141 (2014-10-10)

¹² http://www.telenir.net/delovaja_literatura/gosudstvennyye_i_municipalnye_finansy/p8.php (2014-10-13)

¹³ http://www.venice.coe.int/wccj/rio/papers/can_binnie_e.pdf (2014-10-17)

¹⁴ <http://www.fja.gc.ca/home-accueil/index-eng.html> (2014-10-17)

¹⁵ Fabien Gïlinas, "Judicial Independence in Canada: A Critical Overview" in Anja Seibert-Fohr, ed., *Judicial Independence in Transition – Strengthening the Rule of Law in the OSCE Region* (Heidelberg: Springer) http://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=1577842 (2014-10-18)

¹⁶ http://www.cba.org/cba/groups/pdf/judicialcomp_general3.pdf (2014-10-19)

¹⁷ <https://www.ucl.ac.uk/constitution-unit/research/judicial-independence/judicial-independence-in-europe.pdf> (2014-10-20) 32 дахь тал.

¹⁸ <http://blogs.loc.gov/law/2013/06/the-italian-legislative-procedure/> (2014-10-20)



шүүхүүдэд 3,051,375,987 евро хуваарилж өгсөн байна. Энэ нь хууль зүйн туслалцаа болон прокурорын зардал ороогүй мөнгөн дүн юм.¹⁹

ХБНГУ:

ХБНГУ-д Холбооны төсвийн тухай хууль тогтоомжоор шүүхийн төсвийг зохицуулдаг. Засгийн газрын төвшинд бүх шүүхийн барилга, тоног төхөөрөмж, туслах ажилтнуудын зардал, төсвийн хуваарилалтыг хариуцдаг. Жилийн төсвийн тооцоог Холбооны засгийн газрын төвшинд Хууль зүйн яам бэлтгэж танилцуулдаг байна. Төсвийг Засгийн газар хэлэлцэж баталсны дараа Парламент нэг бол өөрчлөлт оруулж, нэг бол эцэслэн баталдаг. Харин Үндсэн хуулийн шүүх нь төсвөө өөрөө боловсруулж, Сангийн Яамаар дамжуулан Засгийн газарт өгч батлуулан, Засгийн газар нь Парламентаар эцэслэн батлах төсвийг өргөн барьдаг байна.²⁰

Болгар Улс:

Улсын төсвийн тухай хууль, Шүүхийн байгууллагын тухай хууль болон улсын жилийн төсвийн журмын талаарх Сайд нарын зөвлөлийн шийдвэр болон Сангийн яамны удирдамжийн дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн төсвийн төслийг боловсруулж, Сайд нарын зөвлөлд улсын төсвийн нэг хэсэг болгуулахаар өргөн барьдаг. Сангийн сайд нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн төслийг авч үзэж, ШЕЗ-д өөрийн мэдэгдлийг бичгээр хүргүүлдэг. Үүнд мөн Прокурорын байгууллагын төсөв багтсан байдаг. Үндэсний Ассамблейгаас орлого, зарлагын гол үзүүлэлт болон шүүхийн байгууллагын төсвийг улсын төсвийн нэгэн бие даасан хэсэг болгон баталдаг.²¹

Унгар улсын шүүхийн захиргаа

Хуучин социалист улсуудад 1989-1990 онд өрнөсөн их өөрчлөлт, шинэчлэлийн дотор шүүхийн шинэтгэлийн үйл явц томоохон байр суурийг эзэлж байлаа. Социалист тогтолцооны үед шүүх эрх мэдэл нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлээс үлэмж хамааралтай байсан туршлагыг халах үүднээс Хууль зүйн сайд болон Дээд шүүхийн ерөнхий шүүгчид харьяалуулж байсан шүүхийн захиргааны чиг үүргийг бие даасан шүүхийн захиргааны байгууллага болох Шүүхийн үндэсний зөвлөлд шилжүүлэв. Улмаар Дээд шүүхийг шүүн таслах чиг үүргийг хэрэгжүүлэгч болгон зохион байгуулжээ. Шүүхийн үндэсний зөвлөлд үлэмж эрх мэдэл шилжүүлсэн хэдий ч Зөвлөлийн даргын албан үүргийг Дээд шүүхийн ерөнхий шүүгч хавсран эрхэлж байсан нь /аль аль нь орон тооны албан тушаал/ олон асуудлыг дагуулж, хэргийн ачаалал шүүхүүдэд харилцан адилгүй, түдгэлзсэн хэрэг, хойшлуулсан шүүх хуралдааны тоо үлэмж нэмэгдсэн нь шүүхийн захиргааны тогтолцоог шинэчлэх үндэс болжээ. Улмаар хууль тогтоогч шүүхийн захиргааны үндсэн чиг үүргийг Шүүхийн захиргааны үндэсний байгууллагын Ерөнхийлөгч хэрэгжүүлэхээр институцийн өөрчлөлт хийж, харин хяналт тавих бүрэн эрхийг Шүүхийн үндэсний зөвлөлд Шүүхийн захиргааны тухай хуулиар олгосон байна. Энэ

¹⁹ The functioning of judicial systems and the situation of the economy in the European Union Member States, 296 дахь тал.

Цахим холбоос http://ec.europa.eu/justice/effective-justice/files/cepej_study_justice_scoreboard_en.pdf (2014-10-21)

²⁰ <https://www.ucl.ac.uk/constitution-unit/research/judicial-independence/judicial-independence-in-europe.pdf> (2014-10-21)

²¹ Consultative Council of European Prosecutors, Replies from Bulgaria (7 February 2012) http://www.coe.int/t/dghl/cooperation/ccpe/opinions/travaux/OP_7_Bulgaria.pdf



зохицуулалт 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.²²

Энэхүү институцийн өөрчлөлтийн хүрээнд шүүхийн захиргааны чиг үүргийг хоёр тусгаарлан зааглажээ. Шүүхийн захиргааны үндсэн чиг үүргийг Шүүхийн захиргааны үндэсний байгууллагын Ерөнхийлөгч хэрэгжүүлэх бол түүний үйл ажиллагаанд Шүүхийн үндэсний зөвлөл хяналт тавихаар заажээ. Шүүхийн захиргааны төв байгууллагын Ерөнхийлөгч нь хуульд заасны дагуу шүүхийн төсөв, санхүүгийн чиглэлээр бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.²³

- (1) Шүүхийн төсвийг Дээд шүүхийн саналыг авсны дагуу төлөвлөж Засгийн газарт уламжлах. Засгийн газар нь шүүхийн төсвийг өөрчлөхгүйгээр улсын нэгдсэн төсвийн төсөлд багтаан парламентад өргөн мэдүүлнэ;
- (2) Шүүхийн төсвийг парламентын төсвийн байнгын хороогоор хэлэлцэхэд оролцох
- (3) Шүүхийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд санхүүгийн жилд төсвийн хуваарилалтыг хийх
- (4) Шүүхийг санхүүгийн удирдлагаар хангах
- (5) Шүүхийн санхүүгийн дотоод аудитыг хэрэгжүүлэх
- (6) Жил тутмын төсөвт шүүх эрх мэдлийн салбарт ажиллагсдын цалингаас бусад эрсдэлийн сангийн хуваарилалтыг хийх /олговор, гэм хорыг нөхөн төлөх гэх мэт/

Швед Улс:

Швед Улсын Шүүхийн захиргаа *Domstolsverket* болон Засгийн газар зөвшилцөн шүүхийн төсвийн хуваарилалтын асуудлыг шийдвэрлэдэг. Шүүхийн захиргаа нь Засгийн газарт төсвийн удирдлагын талаар тайлагнах ёстой байдаг. Засгийн газрын шийдвэрээр Шүүхийн захиргааны гишүүдийг томилдог тул шүүхийн төсвийг батлахад тодорхой хэмжээгээр Засгийн газар оролцож, улмаар Швед Улсын Парламент шүүхийн төсвийг баталдаг байна.²⁴

²² Унгар улсын Үндсэн хуулийн шүүхийн албан ёсны вэбсайт <http://www.lb.hu/en/english/judicial-reform>

²³ БНУУ-ын “Шүүх, шүүхийн захиргааны тухай хууль”-ийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэг

Цахим холбоос: [http://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF\(2012\)007-e](http://www.venice.coe.int/webforms/documents/?pdf=CDL-REF(2012)007-e)

²⁴ <https://www.ucl.ac.uk/constitution-unit/research/judicial-independence/judicial-independence-in-europe.pdf>



Хүснэгт 2. Швед Улсаас жил бүр батлан гаргадаг шүүхийн нийт төсөв болон улсын төсөвт эзлэх хувь:

Шүүхийн төсөв, хуваарилалт	Төсөв /Евро/	Төсөв еврогоор /Нэг хүн амд ногдох/	Засгийн газрын нийт зардалд эзлэх %
Бүх шатны шүүхийн үйл ажиллагаанд хуваарилсан жилийн нийт батлагдсан төсөв	557,260,358	59.2	0.30%
Төрөөс жил бүр (нийт) цалинд хуваарилсан төсөв	394,206,713	41.9	0.22%
Төрөөс жил бүр мэдээллийн автоматжуулалтад хуваарилсан төсөв (тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ)	13,108,158	1.4	0.01%
Төрөөс жил бүр шүүхийн байгууламжид хуваарилсан төсөв (засвар үйлчилгээ, үйл ажиллагааны зардал)	78,077,930	8.3	0.04%
Төрөөс жил бүр сургалт, судалгаа, боловсролд хуваарилагдах төсөв	6,873,752	0.7	0.00%

Шүүхийн нэгдсэн төсөв нь 4.064.159.050 евро байна. Үүнд шүүхийн төсөв, хууль зүйн туслалцаа үзүүлэх зардал, прокурор, хорих байгууллагын зардал, үйлчилгээ, насанд хүрээгүй этгээдийн хамгаалах зардал болон бусад төсвийн зардлыг багтаадаг.

Хэдийгээр тус лавлагаанд цөөн тооны улсыг жишээ болгон судалсан²⁵ хэдий ч ерөнхий чиг хандлагаас нь харахад гадаад улсууд шүүхийн төсвийг боловсруулах, төлөвлөх зэргээрээ өөр хоорондоо ялгаатай байна. Түүнчлэн тухайн улс орон шүүх эрх мэдэлдээ хэр их төсвийг хуваарилдаг, энэ нь тухайн улс орны нийт жилийн төсвийн хэдэн хувийг эзэлдэг зэрэг үзүүлэлтийг тухайн улсын шударга ёсны хэмжүүр болгож авч үздэг байна. Ийнхүү шүүхийн төсөв тухайн улс орны төсвийн хэдэн хувийг эзэлдэг талаар Европын холбооны улсуудын тоон мэдээллийг График 1-д харуулав.²⁶

АНУ:

АНУ-д Төсөв болон нягтлан бодох бүртгэлийн тухай хууль */Budget and Accounting Act of 1921/*, Конгрессийн төсөв болон төсвийн зарцуулалтад хяналт тавих тухай хууль */Congressional Budget and Impoundment Control Act of 1974/* болон бусад төсвийн хууль тогтоомжоор шүүхийн төсвийг зохицуулдаг.

Төсөв болон нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу Ерөнхийлөгчийн улам бүр нэмэгдэх болсон нөлөөллөөс болгоомжилж, Конгресс тус хуульд томоохон өөрчлөлт оруулахыг зорьсон. Учир нь 1921 оны хуулийн дагуу байгуулагдсан Төсвийн товчоо нь (хожим нь, 1971 онд Удирдлага болон төсвийн алба */Office of Management and Budget/* нэртэй болсон) төсвийн талаарх мэдээллийг Ерөнхийлөгчид бэлтгэн хүргүүлдэг ба энэ нь Ерөнхийлөгчид улсын төсвийн талаарх мэдээллийг “өмчлөх, хянах” бололцоог олгож байв. Харин Конгресст төсөв, эдийн засгийн мэдээллийг нэгтгэн боловсруулдаг, засгийн газраас хараат бус, бие даасан судалгаа шинжилгээ хийдэг, засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөлд төвийг сахисан, үнэн бодит, шинжлэх ухааны үндэслэлтэй дүн

²⁵ Шүүхийн төсөв батлахтай холбоотой бусад улсын туршлага болон холбогдох мэдээллийг ШСМСХ-гээс 2013 онд гүйцэтгэсэн “Шүүхийн төсвийг батлах: Шүүхийн хараат бус байдлыг хангах нь” лавлагаанаас үзнэ үү.

²⁶ http://ec.europa.eu/justice/effective-justice/files/cepej_study_justice_scoreboard_en.pdf (2014-10-22)



шинжилгээ хийдэг, Конгрессын гишүүд болон байнгын хороодод төсөвтэй холбоотой шаардлагатай бусад мэдээ мэдээллийг гаргаж өгдөг байгууллага үгүйлэгдэж байв. Тухайн үед Конгрессын гишүүд Ерөнхийлөгч асан Ричард Никсоныг төсвийн нөөц хөрөнгийг Конгрессоос баталсан төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулахад хойрго хандаж байгааг буруушааж байв. Түүнчлэн зарим гишүүд гүйцэтгэх засаглалын боловсруулж, Конгрессод оруулж ирсэн төсвийн тухай мэдээллийг үнэн зөв гэдэгт эргэлзэж байгаагаа ч илэрхийлж байсан. Эдгээр болон бусад шалтгаанаар 1974 онд Конгрессын төсөв болон төсвийн зарцуулалтад хяналт тавих тухай хуулийг баталжээ. Тус хуулиар Ерөнхийлөгчийн төсөв хөрөнгийг захиран зарцуулахад хяналт тавих шинэ процедурыг хуульчилж өгсөн. Тус хуулиар Ерөнхийлөгчөөс хамаарахгүйгээр Конгресс шаардлагатай гэж үзэж байгаа төсвийн тэргүүлэх чиглэлийг өөрөө тодорхойлж, хэрэгжүүлэхэд нь хяналт тавих боломжтой болсон байна.²⁷

АНУ-ын Шүүхийн захиргааны газар /Administrative Office of the United States Courts/-ын Гүйцэтгэх хороо /Executive Committee/ нь Конгрессын баталсан төсөвт тулгуурлан Үндэсний шүүхийн санхүүгийн төлөвлөгөөг боловсруулан санхүүгийн жилийн эхэнд баталдаг. Шүүхүүдийн захиргааны газар нь Шүүхийн бага хурлаар баталсан төсвийн төслийн саналыг Удирдлага болон төсвийн алба /Office of Management and Budget/-нд 10 дугаар сард буюу санхүүгийн жилийн эхэнд явуулж, шүүхийн төсвийг Ерөнхийлөгч Конгресст өргөн барих нэгдсэн төсөвт тусгуулдаг байна. Үүний дараа Ерөнхийлөгчийн өргөн барьснаар Конгресс баталдаг. Төсвийн удирдлагын газар нь Шүүхүүдийн захиргааны газраас ирүүлсэн төсвийн саналыг өөрчлөлт оруулалгүйгээр өргөн мэдүүлдэг байна.²⁸ 2013 оны байдлаар АНУ-ийн шүүхийн төсөв нь үндэсний нийт төсвийн 1 хувь /36.5 тэрбум доллар/-ийг эзэлж байна.²⁹ /Хүснэгт 1/

Хүснэгт 1. АНУ-ын шүүхийн төсөв (тэрбум ам.доллар-аар):

Салбар	Өргөн мэдүүлсэн төсвийн санал	Зайлшгүй шаардлагатай төсвийн хэмжээ	Нийт	Нийт хувиар
Хууль зүйн салбар	23.9	12.7	36.5	1.0%

АНУ-ын холбооны шүүгчдийн цалингийн хэмжээ болон нэмэгдэл

АНУ-ын Холбооны шүүгчийн цалинг АНУ-ын Конгрессоос тогтоодог ба аль шатны шүүхийн шүүгч гэдгээс хамааран АНУ-ын Үндсэн хуульд хэсэгчлэн зохицуулсан байна. Тухайлбал, АНУ-ын Үндсэн хуулийн III дугаар зүйлийн 1 дэх хэсэгт АНУ-ын Дээд шүүх болон Конгрессоос шаардлагын дагуу тухай бүр байгуулах доод шатны шүүхүүдийн шүүгчид тогтоосон хугацаанд алба хашсанахаа төлөө цалин дээр нөхөн олговор авах бөгөөд албан тушаалдаа байх хугацаанд нь түүнийг бууруулж болохгүй гэж заасны дагуу АНУ-ын Холбооны шүүгчид цалин дээр нөхөн олговор авдаг байна.³⁰

Бусад шүүхийн шүүгчдийн цалин, нөхөн олговрын тухай Үндсэн хуулийн шууд хязгаарлалт байхгүй тул цалингийн хэмжээг өөрчлөн тохируулж болдог байна. Гагцхүү хуулиар тогтоосон жагсаалтаар энэ төрлийн цалингийн асуудлыг

²⁷ УИХ-ын тамгын газар Судалгаа шинжилгээ, олон нийттэй харилцах төв, “Төсвийн харилцааны зохицуулалт, бусад орнуудын туршлага, хараат бус, бие даасан байгууллагуудын төсвийн харилцаа, өнөөгийн байдал” харьцуулсан судалгаа, Улаанбаатар, 2009 он. 16-17 дахь тал.

²⁸ https://bulk.resource.org/courts.gov/ao/Understanding_Judiciary_Budget_Process.pdf (2014-10-10)

²⁹ http://en.wikipedia.org/wiki/2013_United_States_federal_budget (2014-10-10)

³⁰ http://en.wikipedia.org/wiki/Federal_judge_salaries_in_the_United_States



зохицуулдаг. Шүүгчийн цалингийн талаарх хэлэлцүүлэг хийх, нэмэгдэл олгох, боловсруулалт хийх зэрэг ажиллагаа нь Үндсэн хууль баталснаас хойш гарч эхэлсэн.

Шүүгчийн цалин нь ерөнхийдөө тухайн ажил албатай нь тохирон нэмэгддэг хэдий ч нөхөн олговор олгох асуудал нь тухайн шүүгчийн албан тушаалд тулгуурлан янз бүр байдаг.

1. АНУ-ын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн Холбооны шүүгчдийн цалин

1990 оноос хойших АНУ-ын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн дагуу томилогдож цалин дээр нөхөн олговор авдаг Холбооны шүүгчдийн жилийн цалинг доорх хүснэгтээр үзүүлэв.³¹

Он	Холбооны районы шүүхийн шүүгч (district judges)	Тойргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч (Circuit Judges)	Дээд Шүүхийн шүүгч (Associate Justices)	Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч (Chief Justice)
2014 ¹	\$199,100	\$211,200	\$244,400	\$255,500
2013	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2012	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2011	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2010	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2009	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2008	\$169,300	\$179,500	\$208,100	\$217,400
2007	\$165,200	\$175,100	\$203,000	\$212,100
2006	\$165,200	\$175,100	\$203,000	\$212,100
2005	\$162,100	\$171,800	\$199,200	\$208,100
2004	\$158,100	\$167,600	\$194,300	\$203,000
2003	\$154,700	\$164,000	\$190,100	\$198,600
2002	\$150,000	\$159,100	\$184,400	\$192,600
2001	\$145,100	\$153,900	\$178,300	\$186,300
2000	\$141,300	\$149,900	\$173,600	\$181,400
1999	\$136,700	\$145,000	\$167,900	\$175,400
1998	\$136,700	\$145,000	\$167,900	\$175,400
1997	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1996	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1995	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1994	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1993	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1992	\$129,500	\$137,300	\$159,000	\$166,200
1991 ²	\$125,100	\$132,700	\$153,600	\$160,600
1990	\$96,600	\$102,500	\$118,600	\$124,000

Дээрх тоо нь, өөрөөр заагаагүй бол, 28 U.S.Code § 5, 44 (d), 135, and/or 461-ийн дагуу гарсан бүх нэмэгдэл нь жил бүрийн цалингийн өөрчлөлтөөс хамаарна.

Тайлбар 1: 2014 оны хувьд АНУ-ын хууль 28 U.S. Code § 44(d)-д тойргийн шүүхийн шүүгчдийн томилгоо, бүрэн эрхийн хугацаа, оршин суух газар, цалингийн талаар, тус хуулийн 461 дүгээр хэсгийн дагуу өөрчлөгдсөн 1967 оны Холбооны Цалингийн тухай хууль (2 U.S.Code 351-361) –ийн 225 дугаар хэсэгт заасны дагуу тухайн жилийн тогтоогдсон хувиар тойргийн шүүхийн шүүгч (давж заалдах шатны

³¹ <http://www.uscourts.gov/JudgesAndJudgeships/JudicialCompensation/judicial-salaries-since-1968.aspx> болон http://www.fjc.gov/history/home.nsf/page/judges_salaries.html



шүүгч) тус бүр цалин авна гэж заасан байна. Мөн түүнчлэн АНУ-ын хууль 28 U.S. Code § 135-д заахдаа тус хуулийн 461 дүгээр хэсгийн дагуу өөрчлөгдсөн 1967 оны Холбооны Цалингийн тухай хууль (2 U.S.Code 351-361) –ийн 225 дугаар хэсэгт заасны дагуу тухайн жилийн тогтоогдсон хувиар Холбооны районы шүүхийн шүүгч (district judge) тус бүр цалин авна гэж заасан байна.³²

Тайлбар 2: 1991 оны эдгээр цалин нь 2 тусдаа өөрчлөлтийг тусгасан ба 1991 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр болсон юм. 1989 оны Ёс зүйн шинэчлэлийн акт (Pub. L. No. 101-194, § 703, 103 Stat. 1716, 1768) –ын дагуу 25 хувийн нэмэгдэл болон 1991 оны төсвийн жилийн амьжиргааны зардлын 3,6 хувийн нэмэгдлийг шүүгч болон бусад захиргааны удирдах албан тушаалтанд олгосон байна.³³ Эдгээр шийдвэрүүд гарснаар өмнө нь орхигдсон байсан цалингийн өөрчлөлтийг оруулахаар тогтоосон байна.

1990 онд Конгрессын зарцуулалт буюу төсөв нь улс төрийн асуудал болж өөрчлөгдсөнөөс үүдэн, хууль тогтоогчид популист сэтгэлгээгээр өөрсдийнхөө амьжиргааны зардлын нэмэгдлийг болиулсан ба үүнд нь шүүгчид ч хамаарсан байна. Түүнчлэн Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд шүүгчийн цалинг албан тушаалдаа байх хугацаанд нь бууруулж болохгүй тухай үзэл санаанд тулгуурлан, түүнчлэн шүүхийг бусад гүйцэтгэх засаглалын салбаруудын нөлөөллөөс хамгаалахын тулд шүүхийн шийдвэрээр 1990 оноос хойш Конгресс цалингийн автомат өсөлтийг зохисгүйгээр суутган авдаг байсныг тогтоосон.³⁴

1989 онд Ёс зүйн шинэчлэлийн актыг шүүхийн болон хууль тогтоогчийн цалингийн тогтолцоо, процессыг тогтвортой байлгах үүднээс баталсан ба АНУ-ын Конгресс 1995 оноос хойш 6 дахь удаагаа 1989 оны Ёс зүйн шинэчлэлийн актын дагуу олгох ёстой шүүгчийн жилийн цалингийн амьжиргааны өртгийн нэмэгдлийг суутган авсан байна. Шүүгчид Дээд шүүх хүртэл эдгээр нэмэгдлийг олгохгүй байгаа нь Үндсэн хууль зөрчиж байгаа тухай давж заалдсан гомдлыг 3 удаа гаргасан байна. Хамгийн сүүлийн жишээ гэхэд Beer болон бусад АНУ-ын эсрэг гаргасан нэхэмжлэл (Beer et al v. United States) юм.³⁵

Beer болон бусад АНУ-ын эсрэг гаргасан нэхэмжлэлтэй холбоотой хэрэгт одоогийн болон хуучны Холбооны шүүгчид нэхэмжлэгчээр Холбооны нэхэмжлэлийн шүүх (Court of Federal claims)-д хандаж, шүүгчийн цалинг багасгаж, шүүгчийн нэмэгдэл цалин болох 1989 оны Ёс зүйн шинэчлэлийн актын дагуу авах ёстой байсан амьжиргааны өртгийн нэмэгдлийг олгохыг болиулсан нь Үндсэн хуулийг зөрчсөн талаар зарга мэдүүлсэн байна. Хариуцагч тал болох АНУ-ын Холбооны засгийн газраас гомдлыг хэрэгсэхгүй болгохоор хүсэлт тавьсан ба 2009 оны 10 дугаар сарын 16-нд Холбооны нэхэмжлэлийн шүүх хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Улмаар нэхэмжлэгчид давж заалдсан ба шүүхийн бүрэн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянан шийдвэрлүүлэхээр хүсэлт тавьсан байна.³⁶ АНУ-ын Холбооны тойргийн давж заалдах шатны шүүх бүрэн бүрэлдэхүүнээр хянан хэлэлцэж шийдвэрээ гаргасан³⁷ ба Конгресс нь 140 дүгээр хэсгийн (Section 140 of P.L. 97-92. Section 140) буруу тайлбарт үндэслэн 1995, 1996, 1997 болон 1999

³² <http://www.law.cornell.edu/uscode/text/28/44>

³³ <http://www.law.cornell.edu/uscode/text/28/44>

³⁴ <http://www.nationaljournal.com/congress/court-rulings-mean-judges-will-get-an-extra-1b-in-pay-and-benefits-20140924>

³⁵ Bruce Moyer. The Beer Case: Less Filling, More Judicial Pay The Federal Lawyer, May 2012, p.6

³⁶ <http://www.cafc.uscourts.gov/images/stories/opinions-orders/10-5012om.pdf>

³⁷ <http://sblog.s3.amazonaws.com/wp-content/uploads/2013/02/United-States-v-Beer-Petition.pdf>



онуудад Холбооны шүүгчид олгох ёстой байсан амьжиргааны өртгийн нэмэгдлийг олгохыг болиулсан, түүнчлэн 2001 болон 2010 онуудад амьжиргааны өртгийн нэмэгдлийг суутган авсан нь Үндсэн хуульд заасан цалин олговор олгох тухай зүйл заалтыг зөрчсөн гэж үзсэн байна.³⁸ Веер-ийн хэргийг холбогдох нэхэмжлэгчид нөхөн олговол зохих мөнгөн дүнг дахин тооцуулж шийдвэрлүүлэхээр Холбооны нэхэмжлэлийн шүүх (Court of Federal claims)-д буцаасан байна.³⁹ Энэ талаар Холбооны засгийн газар Дээд шүүхэд давж заалдах хүсэлтийг 2014 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд гаргаж болох тухай дурдсан ба Холбооны засгийн газрын Хууль зүйн яам (Department of Justice) –ийн ерөнхий өмгөөлөгч (Attorney general) АНУ-ын Төлөөлөгчдийн Танхим (House of Representatives)-д хандаж энэ хэрэгт АНУ-ын Засгийн газар АНУ-ын Дээд шүүхэд давж заалдахгүй тухайгаа бичгээр илэрхийлсэн байна.⁴⁰

Улмаар Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Жонн Робертсоос эхлэн 2000 гаруй Холбооны шүүгчид 1 тэрбум орчим ам.долларыг цалиндаа хувааж авч, дараагийн 10 жилд ашгийг нь хүртэхээр болсон байна. Конгрессын төсвийн албаны дарга Дуглас Элмэндорф “Эдгээр шийдвэр болон холбогдох захиргааны үйлдлийн үр дүнд ихэнх шүүгчид цалингийн автомат өсөлт болон жил бүрийн нэмэгдэл, түүнчлэн өмнө авах ёстой байсан цалингийн автомат нэмэгдлийн буцаан олголтыг авна” гэж хэлсэн байна.⁴¹

Холбооны шүүгчид энэ шийдвэрийн дагуу үр ашгийг нь хүртэж эхэлсэн ба 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тэдний цалинг 14 хувь буюу өмнөх жилүүдийн олгогдоогүй нэмэгдлийг нэмсэн байна. Үр дүнд нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалинг 199,100 ам.доллар, Тойргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн цалинг 211,200 ам.доллаар, Дээд Шүүхийн шүүгчийн цалинг 244,400 ам.доллар, Дээд Шүүхийн Ерөнхий шүүгчийн цалинг 255,500 ам.доллаар тогтоосон байна. Эдгээр цалингийн түвшинг 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн бүх холбооны засгийн газрын ажилтан, албан хаагчдад 13655 дугаартай Гүйцэтгэх тоот (Executive Order No. 13655 (Dec. 23, 2013)) -ын дагуу олгож эхэлсэн амьжиргааны зардлын нэмэгдэл болох 1 хувийн дагуу өөрчлөн нэмэгдүүлсэн байна.

2. Холбооны бусад шүүхийн шүүгч буюу АНУ-ын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд хамаардаггүй шүүгчдийн цалин, олговор

- *Магистратын шүүгч*

1988 оноос хойш АНУ-ын Шүүхийн Зөвлөгөөн (Judicial Conference of the United States) –өөс магистратын шүүхийн шүүгчдийн цалинг тогтоодог ба энэ нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалингийн 92 хувиас хэтэрч болдоггүй байна.⁴²

- *Дампуурлын хэргийн шүүгч*

³⁸ <http://www.law.cornell.edu/supremecourt/text/425/130>

³⁹ http://www.americanbar.org/publications/governmental_affairs_periodicals/washingtonletter/2012/december/classaction.html

⁴⁰ <http://www.justice.gov/sites/default/files/oip/legacy/2014/07/23/10-29-2013.pdf>

⁴¹ <http://www.nationaljournal.com/congress/court-rulings-mean-judges-will-get-an-extra-1b-in-pay-and-benefits-20140924>

⁴² “History of the Federal Judiciary”. Federal Judiciary Center. Retrieved 11 January 2014.



1988 оноос хойш дампуурлын хэргийн шүүгчид нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалингийн 92 хувьтай тэнцэхүйц хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг.⁴³

- *Татварын хэргийн шүүхийн шүүгч*

Татварын хэргийн шүүхийн шүүгч нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалинтай адил хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг.⁴⁴

- *Холбооны нэхэмжлэлийн шүүхийн шүүгч (Court of Federal claims judges)*

Холбооны нэхэмжлэлийн шүүхийн шүүгч нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалинтай адил хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг.⁴⁵

- *Зэвсэгт хүчний давж заалдах шатны шүүхийн шүүгч*

Зэвсэгт хүчний давж заалдах шатны шүүх Холбооны тойргийн давж заалдах шүүхийн шүүгчийн цалинтай адил хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг.⁴⁶

- *Ахмад дайчдын нэхэмжлэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгч*

Ахмад дайчдын нэхэмжлэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалинтай адил хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг.⁴⁷



⁴³ http://www.fjc.gov/history/home.nsf/page/js_5.html болон "28 U.S.C. § 153". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.

⁴⁴ "26 U.S.C. § 7443". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.

⁴⁵ "28 U.S.C. § 172". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.

⁴⁶ "10 U.S.C. § 942". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.

⁴⁷ "38 U.S.C. § 7253". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.



ДҮГНЭЛТ

НҮБ, шүүхийн хараат бус байдлыг хангах асуудлаарх олон улсын байгууллагуудын батлан гаргасан хэм хэмжээ, зарчмуудад шүүхийн төсөв, шүүгчийн цалинг бууруулахгүй байх нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд нэн чухал болохыг онцолсон байна. Мөн гадаадын бусад улс оронд шүүхийн төсвийг бууруулахгүй байх асуудлыг чухалчлан авч үзэж, холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулсан байна.

Монгол Улсын хувьд 2013 оноос эхлэн Шүүхийн багц хууль хэрэгжиж эхэлснээр шүүхийн эдийн засгийг баталгааг зохих ёсоор бүрдүүлэн хэрэгжүүлж эхэлсэн боловч, Улсын Их Хурлаас 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан “Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй” гэснийг хүчингүй болгосон. Гэхдээ Улсын Их Хурлын 2015.11.13-ны өдрийн “Бүх шатны шүүхийн шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолоор шүүгчийн цалинг бууруулаагүй шүүхийн эдийн засгийн баталгаа бодитоор хөндөгдөөгүй гэж үзэх нөхцөл болсон байна.

Харин Засгийн газраас 2016.08.23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шүүхийн урсгал төсвийн зардлыг батлагдсан хэмжээнээс 3.9 тэрбум төгрөгөөр, шүүгчийн цалингийн санг 3.2 тэрбум төгрөгөөр бууруулахаар тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн шинжтэй, шүүхийн хараат бус байдалд заналхийлсэн шинжтэй үйлдэл болж байна.

Иймд Улсын Их Хурлын зүгээс Үндсэн хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн шүүхийн төсөв, шүүгчийн цалинг бууруулахгүй байх арга хэмжээ авах нь зүйтэй байна.





ХАВСРАЛТ

ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ БОЛОН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ СОФИГИЙН ТУНХАГЛАЛ

1. Бие даасан болон хариуцлагатай шүүх нь иргэдэд үр нөлөөтэй шударга ёсыг түгээн дэлгэрүүлэхэд гол хүчин зүйл болох бөгөөд энэ нь ардчилсан нийгмийн эрх зүйт ёсны гол үзүүлэлт болно.
2. Шүүх нь хариуцлагатай байж, ёс зүйг удирдлага болгон хараат бус сахилга-ёс зүйн тогтолцоонд захирагдах ёстой.
3. Засгийн газрын зардал хэмнэлт нь шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг сулруулж болохгүй.
4. Санхүүгийн тогтвортой байдал, ажлын байрны баталгаа, захиргааны бие даасан байдал нь бие даасан, хараат бус шүүхийн зайлшгүй хамгаалалт болно.
5. Шүүхийн хараат бус байдлын хамгаалалт нь шүүхийн төсөв, тэдний ажлын нөхцөл байдалтай холбоотой бүхий л асуудлыг авч үзэх, засгийн газарт санал, зөвлөмж гаргах эрх бүхий шүүхийн зөвлөл эсхүл түүнтэй адил бие даасан байгууллагаас зохих ёсоор чиг үүргээ хэрэгжүүлснээр хэрэгжих боломжтой болно.
6. Шүүхийн бие даасан байдлыг, нэн ялангуяа, эдгээрийг аюул заналхийлэл учирсан үед хамгаалж, бэхжүүлэх нь Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Холбоо болон бүх Шүүхийн Зөвлөлүүдийн нэн тэргүүний үүрэг болно.
7. Шүүгчид улс төрийн маргаантай асуудлаар чимээгүй суух ёстой гэсэн уламжлалт хандлага шүүхийн бие даасан, хараат бус байдалд аюул заналхийлэл учирсан тохиолдолд үйлчлэх ёсгүй. Одоогоор засгийн газраас шүүгчид болон шүүхийн зөвлөлийн бие даасан, хараат бус байдалд халдах гэсэн аливаа саналын эсрэг тодорхой бөгөөд итгэлтэйгээр өөрийн эсэргүүцлийг илэрхийлэх нэгдмэл үүрэг Европын шүүхэд оногдож байна.
8. Бодит байдал болон 2013 оны 6 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд Софид болсон Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Холбооны Ерөнхий Ассамблейд оролцсон гишүүн улс орнууд болон ажиглагчдаас өгсөн саналыг харгалзан үзсэний үндсэн дээр Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Холбооноос шүүхийн тогтолцооны өвөрмөц онцлог, шүүхийн бие даасан байдлыг хамгаалж, нийт иргэдэд үр ашгаа үзүүлэх үр дүнтэй шүүхийн тогтолцоо болон түүний өсөлтийг хангасан Европын шүүхийн бие даасан эрх зүйт ёсны механизмыг бий болгохыг уриалж байна.

ЕВРОПЫН ШҮҮХИЙН ЗӨВЛӨЛҮҮДИЙН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙ⁴⁸

⁴⁸ Европын Шүүхийн Зөвлөлүүдийн Холбоо нь Европын холбооны гишүүн улсуудаас бүрдсэн бөгөөд тус холбооны зорилго нь гишүүн улсуудын шүүхийн зөвлөлүүдийн дунд нийтлэг ойлголтыг түгээн дэлгэрүүлэх, тэдний хамтын ажиллагааг сайжруулахад оршино. 2004 онд тус холбоог олон улсын төрийн бус байгууллага гэсэн статустайгаар албан ёсоор байгуулжээ. Тус холбооноос 2014-2018 оны стратеги төлөвлөгөөг батлан гаргасан ба үүнд, “(1) Европын холбоо ба Европын бусад улсуудад бие даасан, хариуцлагатай шүүх тогтолцоог бэхжүүлэх, (2) Европын холбооны иргэдийн эрхийг хамгаалсан үр нөлөөтэй шүүхийг бэхжүүлэх, (3) шүүгч болон бусад шүүх эрх мэдлийн байгууллагуудын хоорондох итгэлцлийг бэхжүүлэх” зэрэг зорилтыг тавьжээ.



ЕВРОП ДАХЬ ШУДАРГА ЁСНЫ ИРЭЭДҮЙН АСУУДЛААРХ ВАРШАВЫН ТУНХАГ⁴⁹

Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээний Ерөнхий Ассамблей
Варшав хот, 2016 оны 6 дугаар сарын 3-ны өдөр батлав.

Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээ нь дараах зүйлсийг анхааралдаа авч:

- (i) Бие даасан, хариуцлагатай шүүхийн төлөөх хамгийн тулгамдсан асуудлуудад практик шийдэл олохоор өөрийн гишүүд болон ажиглагчдыг идэвхжүүлэх бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулсан;
- (ii) Чанартай шийдвэр гаргахад шаардлагатай бүрдлүүдийг тодорхойлсон ба Европын холбоо, түүний гишүүн болохоор нэр дэвшигч улсуудын шүүхийн шударга байдлыг үнэлэх, хэмжихэд туслахуйц шүүхийн тогтолцооны чанарын үзүүлэлтийг тодорхойлохыг эрмэлзэж,
- (iii) Шүүхийн зөвлөлийн Европ дахь шүүхийн тогтолцооны санхүүжилт дэх оролцоотой холбоотойгоор Зөвлөл болон түүнтэй адилтгах байгууллагуудын ажилд шүүхийн бус, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах сайн жишгийг бий болгосон

бөгөөд Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээний гишүүн болон ажиглагчид Варшав хотноо 2016 оны 6 дугаар сарын 1-3-ны өдрүүдэд хуран цуглаж, дараах зүйлийг тунхаглаж байна:

1. Шүүхийн зөвлөл, түүнтэй адилтгах удирдах байгууллага нь шүүхийн чанарыг үнэлэх үйл явцад оролцохтой холбоотойгоор:
 - Шүүхийн чанарын үнэлгээний шалгуур үзүүлэлтийг багтаасан чанарын хүчин зүйлсийн хамрах хүрээг тодорхойлох;
 - Шүүхийн шийдвэр гаргах үйл явцын чанарыг үнэлэх, сайжруулах аргыг тодорхойлох;
 - Шүүхийн тогтолцоон дахь иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх сайн туршлага бий болгож, хэрэгжүүлэх;
 - Шүүхийн тогтолцоо буюу шүүхийн бие даасан байдал, шүүгчдийн хараат бус байдалд саад учруулахгүй байх тогтолцоог хангах.
2. Зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүхийн бус гишүүдийн төлөөлөл орохтой холбоотой:
 - Шүүхийн зөвлөл, түүнтэй адилтгах байгууллагын бүрэлдэхүүнд нийгмийн олон талт байдлыг хангахад шаардлагатай шүүхийн бус гишүүн оруулах;
 - Шүүхийн бус гишүүд нь шүүгчтэй адил бие даасан, хараат бус, шударга байх шаардлагатай бөгөөд ийм гишүүд нь улс төрч, Хууль зүйн сайд байж болохгүй;
 - Шүүхийн бус гишүүд нь шүүхийн гишүүдтэй адил статустай байх бөгөөд санал өгөх эрхтэй байна.
3. Шүүхийн тогтолцооны төсөвтэй холбоотой:
 - Улс төрийн зохисгүй нөлөөллөөс тогтолцооны хувьд төдийгүй практикт ангид байх төсвийг бүрдүүлэх, шүүхүүд бодитой, ил тод байдал дээр суурилсан санхүүжилттэй байх;

⁴⁹ Орчуулсан Л.Галбаатар.

Эх хувилбарыг эндээс үзнэ үү: [The Warsaw Declaration on the Future of Justice in Europe](http://www.ency.eu/images/stories/pdf/GA/Warsaw/ency_warsaw_declaration_final.pdf)
http://www.ency.eu/images/stories/pdf/GA/Warsaw/ency_warsaw_declaration_final.pdf



- Шүүхийн зөвлөл, түүнтэй адилтгах байгууллага нь төсвийн үйл явцын бүх үе шатанд ойр байх бөгөөд шүүхүүдийн нөөц, хөрөнгө нь шүүхийн тогтолцоо үр дүнтэй, үр ашигтай байх шаардлагад нийцсэн байх;
- Төсвийн тэргүүлэх чиглэл нь шүүхийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн хамтын ажиллагаатай холбоотой байх бөгөөд шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөхгүй байна.

4. Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээ нь 21 дүгээр зуун дахь Европын шүүхийн тогтолцооны удирдлагыг мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний үр дүн үндсээр нь өөрчлөхийг хүлээн зөвшөөрч байна. Европын бүх иргэд маргааныг онлайнаар шийдвэрлэх болон бусад технологийг ашиглах замаар бага зардлаар, түргэн хугацаанд илүү үр дүнтэйгээр шүүхийн үйлчилгээг хүртэх бололцоотой болж байна. Энэ нь Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээ болон түүний гишүүд, ажиглагчдын хувьд Европын иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг илүү үр дүнтэй хангах бие даасан, хариуцлагатай шүүхийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой байх болно.

5. Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээ нь Туркийн засгийн газрын зүгээс шүүхийн бие даасан байдлын зарчимтай нийцэхгүйгээр шүүгчдийг шилжүүлэх, бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах, яллах арга хэлбэрт ихэд зовниж байна. Иймд хуульд заасан эрх бүхий бие даасан байгууллагаас ил тод хянан шийдвэрлэх ажиллагааны дагуу эцэслэн шийдвэрлэснээс бусад тохиолдолд шүүгчийг огцруулахгүй байх, шилжүүлэхгүй байх, албан тушаал бууруулахгүй байх зарчмыг Туркийн шүүхийн Зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын зүгээс бүрэн хэрэгжүүлж ажиллахыг уриалж байна.

6. Польш улсад өрнөж буй нөхцөл байдалтай холбоотойгоор Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээ нь шүүхийн бие даасан байдлыг хангахад гүйцэтгэх удирдлага чухал үүрэгтэй бөгөөд зөвхөн Шүүхийн зөвлөл болон шүүгчидтэй өөртэй нь харилцан зөвлөлдсөний дараагаар шүүхийн шинэтгэлийг хэрэгжүүлэх нь зүйтэй болохыг онцлон тэмдэглэж байна.

7. Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээ нь шүүхийн бие даасан байдлын үндсэн суурь зарчмуудыг хангах хүртэл Турк болон Польш улс дахь үйл явцын мониторингийг үргэлжлүүлэн хийнэ.